



ЗАМ, ТЭЭВЭР

2025

ЭХНИЙ ХАГАС ЖИЛ



СТАТИСТИК



СУДАЛГАА, СТАНДАРТ,
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
2025 ОН

АГУУЛГА

ДҮГНЭЛТ..... 5

БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ 7

 Ачаа тээвэр 7

 Зорчигч тээвэр..... 11

БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР..... 14

 Зорчигч тээвэр..... 14

 Ачаа тээвэр 15

 Тээврийн хэрэгслийн бүртгэл 18

БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР..... 22

 Зорчигч тээвэр..... 22

 Ачаа тээвэр 23

БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР 288

 Зорчигч тээвэр..... 288

 Ачаа тээвэр 311

 Нислэгийн үзүүлэлт 322

ХАВСРАЛТ..... 333

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Ачаа тээвэр, эхний хагас жил	7
Зураг 2 Ачаа тээврийн өөрчлөлт.....	7
Зураг 3 Тээврийн салбарын эзлэх жин.....	8
Зураг 4 Ачаа эргэлт, сая.тонн/км	8
Зураг 5 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар.....	8
Зураг 6 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт	8
Зураг 7 Ачаа тээврийн хэмжээ, хүлээгдэж буй гүйцэтгэлээр	9
Зураг 8 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин	9
Зураг 9 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин	9
Зураг 10 Тээвэрлэлийн төрөл, салбараар.....	10
Зураг 11 Улс хоорондын ачаа тээвэр.....	10
Зураг 12 Зорчигч тээвэр.....	11
Зураг 13 Зорчигч тээврийн өөрчлөлт.....	12
Зураг 14 Зорчигч тээврийн эзлэх хувь.....	12
Зураг 15 Олон улсын зорчигч тээвэр	12
Зураг 16 Орон нутгийн зорчигч тээвэр.....	13
Зураг 17 Зорчигч эргэлт, сая хүн/км	13
Зураг 18 Автотээврийн зорчигч, сая хүн	14
Зураг 19 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр	14
Зураг 20 Автотээврийн зорчигч эргэлт.....	14
Зураг 21 Автотээврийн ачаа тээвэр	15
Зураг 22 Автотээврийн экспортын ачаа.....	16
Зураг 23 Экспортын ачаа эзлэх хувь.....	16
Зураг 24 Автотээврийн импортын ачаа	16
Зураг 25 Боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, эзлэх хувь	17
Зураг 26 Тээврийн хэрэгслийн ангилал	18
Зураг 27 Жолооны хүрдний байрлал	18
Зураг 28 Хөдөлгүүрийн багтаамж.....	18
Зураг 29 Автомашины насжилт	Error! Bookmark not defined.
Зураг 30 Орон нутаг дахь тээврийн хэрэгслийн төрөл	21
Зураг 31 Төмөр замын зорчигч	22
Зураг 32 Төмөр замаар зорчсон зорчигдын тоо, хоногоор	22
Зураг 33 Төмөр замын ачаа тээвэр.....	23
Зураг 34 Төмөр замын тээвэрлэлтэд эзлэх хувь	23
Зураг 35 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин	24
Зураг 36 Төмөр замаар тээсэн ачааны төрөл.....	24
Зураг 37 Дотоодын ачаа байгууллагаар	24
Зураг 38 Уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл	24
Зураг 39 Хүлээн авсан вагон	25
Зураг 40 Хүлээлгэн өгсөн вагон	25
Зураг 41 Вагон солилцоо, хилийн өртөөгөөр.....	27
Зураг 42 Хөдлөх бүрэлдэхүүний төрөл	27
Зураг 43 Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч.....	Error! Bookmark not defined.
Зураг 44 Агаарын тээврийн зорчигч	27
Зураг 45 Олон улс, орон нутагт зорчигчдын эзлэх хувь	28
Зураг 46 Зорчигч тээврийн үзүүлэлтүүд	28
Зураг 47 Олон улсын зорчигч, чиглэлээр	29
Зураг 48 Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгчээр	29
Зураг 49 Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	30
Зураг 50 Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгчээр	30

Зураг 51 Агаарын тээврийн ачаа, шуудан	31
Зураг 52 Ачаа, шуудангийн эзлэх хувь.....	31
Зураг 53 Ачаа тээврийн үзүүлэлт	31
Зураг 54 Нислэгийн үзүүлэлт.....	32

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт	Тодорхойлолт*
Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

Хянасан:

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн дарга Ц.Мядагмаа

Боловсруулсан:

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Нэмэхжаргал

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн мэргэжилтэн Э.Энхзаяа

Энэхүү эмхэтгэлийг УСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

¹ Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

ДҮГНЭЛТ

Ачаа тээвэр

2025 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврээр нийт 60.4 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5%-аар буурсан.

Автотээврийн ачаа 39.5 сая тонн болж өмнөх оноос 4.8%-аар, төмөр замын тээврийн ачаа 20.9 сая тонн болж өмнөх оноос 4.0%-аар тус тус буурсан бол агаарын тээврийн ачаа 4.6 мянган тонн болж өмнөх оноос 0.6%-аар өссөн байна.

Нийт ачаа тээврийн 65.4%-ийг автотээвэр, 34.6%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

Бүх төрлийн тээврээр тээвэрлэсэн экспортын ачаа нийт ачаа тээврийн 72.0%-ийг эзэлж байгаа бөгөөд 2025 оны эхний хагас жилд 43.5 сая тонн болж өмнөх оноос 4.6%-аар буурсан үзүүлэлттэй байна.

2025 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврийн хэрэгслээр тээсэн импортын ачаа 3.3 сая тонн болж өмнөх оноос 0.7%-аар төмөр замаар дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 2.9 сая тонн болж өмнөх оноос 10.2%-аар тус тус өссөн бол дотоодын ачаа 10.7 сая тонн болж өмнөх оноос 8.9% буурсан үзүүлэлттэй байна.

2024 оны эхний хагас жилд улс хоорондын ачаа тээвэр 51.8 сая тонн болж нийт ачаа тээврийн 82.4%-ийг эзэлж байсан бол 2025 онд 49.7 сая тонн болж нийт ачаа тээврийн 82.2% болсон байна.

Эхний хагас жилийн байдлаар төмөр замаар тээвэрлэсэн транзит ачаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлт үзүүлсэн бол нийт экспортын хэмжээ болон дотоодын ачаа тээврийн хэмжээ бууралттай гарсан шалтгаан нь Гашуунсухайт, Ханги зэрэг боомтуудын экспортын ачаа буурсан нь голлон нөлөөлжээ.

Нийт ачаа эргэлт 16,495.7 сая тонн.км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.31%-аар буурсан байна.

Зорчигч тээвэр

2025 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврээр нийт 77.1 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 2.8%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо 2025 онд 74.1 сая болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8%-аар өссөн байна.

Харин 2025 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврээр олон улс болон орон нутагт зорчигчдын тоо 3.0 сая болж өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Үүнээс агаарын тээврээр 1.0 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 14.3% өссөн бол автотээврээр 1.1 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 1.6%-аар төмөр замаар 862.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 11.9%-аар тус тус буурчээ.

Төмөр замаар олон улсад зорчигчдын тоо 21.7 мянга хүрч өмнөх оны мөн үеэс 2.6%-аар, орон нутгийн зорчигч 841.1 мянга болж өмнөх оноос 12.1%-аар буурч нийт төмөр замын зорчигчдын тоо өмнөх оноос 11.9%-аар буурсан байна.

Автотээврээр орон нутагт зорчих иргэдийн тоо 800.4 мянга хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.9%-аар өссөнч олон улсад зорчих иргэдийн тоо 293.8 мянга болж 19.0%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Агаарын тээврээр олон улсад зорчих иргэдийн тоо 855.9 мянга болж 17.8%-аар өссөн нь нийт олон улсад зорчигчийн тоо нэмэгдэхэд голлон нөлөөлжээ.

Зорчигч эргэлт 3,976.7 сая хүн.км болж өмнөх оны мөн үеэс 10.8%-аар өсжээ.

АЧАА

60.4 сая тонн

Өмнөх оны мөн
үеэс 4.5% ↓

ЗАМ, ТЭЭВЭР
2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС
ЖИЛ

ЗОРЧИГЧ

77.1 сая хүн

Өмнөх оны мөн
үеэс 2.8% ↑

4.6 мян. тонн

Өмнөх оны мөн
үеэс 0.6% ↑



1.0 сая хүн

Өмнөх оны мөн
үеэс 14.3% ↑

20.9 сая тонн

Өмнөх оны мөн
үеэс 4.0% ↓



862.8 мян хүн

Өмнөх оны мөн
үеэс 11.2% ↓

39.5 сая тонн

Өмнөх оны мөн
үеэс 4.8% ↓




75.2 сая хүн

Өмнөх оны мөн
үеэс 2.9% ↑

БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД
АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ **60.4**
САЯ ТОНН БОЛЛОО.

Зураг 1 Ачаа тээвэр, эхний хагас жил



Ачаа тээвэр


Бүх төрлийн тээврээр 2025 оны эхний хагас жилд нийт 60.4 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 4.5%-аар буурсан. Үүнээс автотээврийн ачаа 39.5 сая тонн болж өмнөх оноос 4.8%-аар, төмөр замын тээврийн ачаа 20.9 сая тонн болж өмнөх оноос 4.0%-аар тус тус буурсан бол агаарын тээврийн ачаа 4.6 мянган тонн болж өмнөх оноос 0.6%-аар өссөн байна.

Нийт ачаа эргэлт 2024 оны эхний хагас жилд 16.9 сая.тн/км байсан бол 2025 оны эхний хагас жилд 16.5 сая.тн/км болж 2.3%-аар мөн буурсан.

Өмнөх онуудын эхний хагас жилд тээвэрлэсэн ачааны хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

Тээврийн төрөл	2022 он хагас жил	2023 он хагас жил	2024 он хагас жил	2025 он хагас жил
Нийт тээсэн ачаа, мянган тонн	23,127.7	49,262.7	63,234.1	60,387.6
Төмөр зам	13,919.2	18,889.6	21,753.6	20,887.7
Автотээвэр	9,202.0	30,368.9	41,475.9	39,495.3
Агаарын тээвэр	6.5	4.1	4.6	4.6
Нийт ачаа эргэлт, сая.тн/км	13,524.4	14,120.2	16,888.8	16,495.7
Төмөр зам	7,060.3	9,482.9	10,392.6	10,560.5
Автотээвэр	6,448.9	4,625.7	6,482.1	5,923.4
Агаарын тээвэр	15.2	11.6	14.2	11.8


Зураг 2 Ачаа тээврийн өөрчлөлт



Монгол Улс өнөөдөр хоёр хөрштэйгөө төмөр замын 3 боомт, авто замын 13 боомтоор экспорт, импортын тээвэр хийж байна.

2024 оны эхний хагас жилд нийт ачаа тээврийн дүнд автотээвэр 66.52%, төмөр замын тээвэр 33.47%, агаарын тээвэр 0.01%-ийг тус тус эзэлж байсан бол 2025 онд 65.4%-ийг автотээвэр, 34.58%-ийг төмөр замын тээвэр, 0.02%-ийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

Зураг 3 Тээврийн салбарын эзлэх жин




Нийт ачаа эргэлт 16,097 сая.тн/км болж 2020 оны түвшингээс 60%-аар, 2021 оноос 50%-аар, 2022 оноос 2.2 дахин, 2023 оноос 17% өссөн бол өмнөх оны мөн үеэс 2.3%-аар өсчээ.

Автотээврийн ачаа эргэлт 2025 оны эхний хагас жилд 5,923.4 сая.тн/км болж өмнөх оноос 8.6%-аар буурсан.

Нийт ачаа эргэлтэд төмөр замын ачаа эргэлт хамгийн өндөр үзүүлэлттэй хэвээр байна. 2025 оны эхний хагас жилд 10,560.5 сая.тн/км болж өмнөх оноос 1.6%, өсчээ.

Зураг 4 Ачаа эргэлт, сая.тонн/км




2025 оны эхний хагас жилд автотээвэрээр тээвэрлэсэн ачааны 95.9%, төмөр замаар тээвэрлэсэн ачааны 47.7% нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн 88.3% буюу 37.9 сая

тонн ачааг автотээвэрээр, 11.7% буюу 5.0 сая тонн ачааг төмөр замаар тээвэрлэсэн байна.


Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийг бүтээгдэхүүнээр авч үзвэл, 37.1 сая тонн буюу 85.5%-ийг нүүрс, 2.9 сая тонн буюу 6.7%-ийг төмрийн хүдэр, 0.9 сая тонн буюу 2.0%-ийг зэсийн баяжмал, 229.3 мянган тонн буюу 0.5%-ийг газрын тос, 573.4 мянган тонн буюу 1.3%-ийг жонш тус тус эзэлж байна.

Зураг 5 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт




Ачаа тээврийг эдийн засгийн салбараар ангилбал, 2025 оны эхний хагас жилд нийт 60.4 сая тонн ачаа тээвэрлэснээс 50.5 сая тонн буюу 83.7%-ийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, 2.4 сая тонн буюу 4.1%-ийг барилгын салбарын бүтээгдэхүүн, 0.5 сая тонн буюу 0.9%-ийг хүнс хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, 6.9 сая тонн буюу 11.4%-ийг бусад салбарын ачаа эзэлж байна.

Зураг 6 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар




Зураг 7 Ачаа тээврийн хэмжээ, хүлээгдэж буй гүйцэтгэл



Үзүүлэлт	Тээврийн төрөл	2024 он хагас жил	2025 он хагас жил
Нийт тээсэн ачаа, сая тонн		63,234.1	60,387.6
Транзит	Төмөр зам	2,641.3	2,910.4
	Төмөр зам	5,465.9	5,497.2
	Автотээвэр	40,088.3	37,961.2
Экспорт		45,554.2	43,458.4
Импорт	Төмөр зам	1,879.6	1,755.2
	Автотээвэр	1,387.5	1,534.1
	Нийт	3,267.2	3,289.3
Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	11,766.9	10,725.0
	Агаар	4.6	4.6
	Нийт	11,771.5	10,729.6

Бүх төрлийн тээврээр тээсэн экспортын ачаа 43.5 сая тонн болж өмнөх оноос 4.6%-аар, дотоодын ачаа 10.7 сая тонн болж өмнөх оноос 8.9%-аар буурсан бол төмөр замаар дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 2.9 сая тонн болж өмнөх оноос 10.2%-аар, импортын ачаа 3.3 сая тонн болж өмнөх оноос 0.7%-аар тус тус өссөн байна.

Зураг 8 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин




2024 оны эхний хагас жилийн байдлаар 73.2%-ийг эзэлж байсан экспортын тээвэр 72.0% болж буурсан бол импортын ачаа нийт тээврийн хэмжээнд эзлэх хувь 5.0%-аас 5.4% болж өсжээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын транзит тээврийн эзлэх хувь 2024 онд 4.2% байсан бол 2025 онд 4.8% болж мөн өссөн байна.

Дотоодын ачаа тээвэр 2024 оны эхний хагас жилд 11.7 сая тонн буюу нийт ачаа тээврийн 17.6%-ийг эзэлж байсан бол 2025 онд 10.7 сая тонн болж буурсан боловч нийт ачаа тээвэрт эзлэх хувийн жин 17.8% болон нэмэгдсэн байна.


Зураг 9 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин



Төмөр замын байгууллагууд эрчим хүчний нүүрс, шахмал түлшний түүхий эдийн тээврийг бүрэн хариуцан нийгмийн хариуцлагын хүрээнд тээвэрлэдэг ба дотоодод тээвэрлэсэн 10.7 сая тонн ачааны 5.8 сая тонн ачаа буюу 54.0%-ийг “Улаанбаатар төмөр зам” ХНН, 1.6 сая тонн ачаа буюу 14.6%-ийг “Монголын төмөр зам”

ТӨХК, 695.7 мянган тонн ачаа буюу 6.5%-ийг “Тавантолгой төмөр зам” ХХК, 1.9 сая тонн буюу 18.1%-ийг “Монголиантранс Логистик” ХХК, 741.6 мянган тонн буюу 6.9%-ийг “Монголиантранс Лайн” ХХК тус тус тээвэрлэсэн.

Зураг 10 Тээвэрлэлтийн төрөл, салбараар




Улс хоорондын ачаа тээвэр буюу экспорт, импортын ачаа тээврийг төмөр зам, автотээвэрээр гүйцэтгэж байгаа бол транзит тээвэр болон дотоодын тээвэрт төмөр зам голлох үүрэг гүйцэтгэж байна.

2025 оны эхний хагас жилд автотээвэрээр экспортын ачааны 87.4%, импортын ачааны 46.6%-ийг тээсэн бол төмөр замаар транзит ачааг 100%, дотоодын ачааны 99.9%, импортын ачааны 53.4%, экспортын ачааны 12.6%-ийг тээвэрлэжээ.

2024 оны эхний хагас жилд улс хоорондын ачаа тээвэр 51.8 сая тонн болж нийт ачаа тээврийн 82.4%-ийг эзэлж байсан бол 2025 онд 49.7 сая тонн болж нийт ачаа тээврийн 82.2% болсон байна.

2025 оны эхний хагас жилд Гашуунсухайт боомтоор хамгийн их буюу 17.7 сая тонн ачаа гарсан нь нийт ачаа гаргалтын 40.7%-ийг эзэлж байгаа бол Шивээхүрэн боомтоор 29.7%-ийн ачаа гарчээ.

Зураг 11 Улс хоорондын ачаа




Улс хоорондын ачаа тээврийн дүнд экспорт 87%, импорт 7%, дамжин өнгөрсөн ачаа 6%-ийг эзэлж байна.

Экспортын ачааны 37.96 сая тонн буюу 87.4%-ийг автотээвэрээр тээвэрлэсэн нь экспортын тээвэрт эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс 0.7%-аар буурсан бол төмөр замаар 5.5 сая тонн буюу 12.6%-ийг тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 0.9%-аар өөсөн байна.

Импортын ачааны 1.8 сая тонн ачаа буюу 53.4%-ийг төмөр замаар тээвэрлэсэн нь импортын тээвэрт эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс 8.6%-аар буурсан бол 1.5 сая тонн буюу 46.6%-ийг автотээвэрээр тээвэрлэсэн нь импортын тээвэрт эзлэх хувийн жин өмнөх оноос 8.6%-аар өсжээ.

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРЭЭР **77.1** **САЯ** ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.

Зураг 12 Зорчигч тээвэр, эхний хагас жил



Зорчигч тээвэр

Бүх төрлийн тээвэрээр 2025 оны эхний хагас жилд нийт 77.1 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 2.8%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо 74.1 сая байна.

Үүнээс агаарын тээврээр 1.0 сая зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 14.3%, автотээврээр 75.2 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.9%-аар тус тус өссөн бол төмөр замаар 862.8 мянган зорчигч тээвэрлэж өмнөх оноос 11.2%-аар буурсан байна.

Тээврийн төрөл	2022 он хагас жил	2023 он хагас жил	2024 он хагас жил	2025 он хагас жил
Нийт зорчигчдын тоо, сая хүн	68,869.3	73,186.1	75,012.3	77,139.6
Автотээвэр	67,500.0	71,401.1	73,110.6	75,213.6
Төмөр замын тээвэр	1,045.8	1,076.7	971.8	862.8
Агаарын тээвэр	323.5	708.4	929.9	1,063.2
Зорчигч эргэлт, сая хүн/км	1,839.3	2,862.3	3,590.4	3,976.7
Автотээвэр	864.0	895.9	1,086.3	1,129.0
Төмөр замын тээвэр	303.6	385.5	380.8	358.3
Агаарын тээвэр	671.7	1,581.0	2,123.4	2,489.4

862.8

мянган хүн (-11.2%)




1.0

сая хүн (+14.3%)



75.2


сая хүн (+2.9%)



Үзүүлэлт	Тээврийн төрөл	2024 он хагас жил	2025 он хагас жил
Нийт зорчигч		75,012.3	77,139.6
Олон улсад зорчигч	Автотээвэр	362.7	293.8
	Төмөр зам	22.2	21.7
	Агаарын тээвэр	726.8	855.9
	Нийт	1,111.7	1,171.4
Орон нутагт зорчигч	Автотээвэр	749.1	800.4
	Төмөр зам	956.7	841.1
	Агаарын тээвэр	203.1	207.3
	Нийт	1,908.9	1,848.8
Нийслэлд зорчигч	Автотээвэр	71,998.8	74,119.4

2025 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврээр улс хооронд болон хот хооронд зорчсон зорчигчдын тоо 3.0 сая болж өмнөх оны мөн үеийн түвшинд хүрчээ.


Зураг 13 Зорчигч тээврийн өөрчлөлт




Үүнээс агаарын тээврээр 1.0 сая зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 14.3%-аар өсөн бол автотээврээр 1.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6%-аар, төмөр замаар 862.8 мянган зорчигч тээвэрлэж өмнөх оноос 11.2%-аар буурсан байна.

Тээврийн төрлөөр авч үзвэл 2025 оны эхний хагс жилд автотээврээр 36.2%, төмөр замаар 28.6%, агаарын тээврээр 35.2% нь зорчсон байна.

Зураг 14 Зорчигч тээврийн эзлэх хувь



Зураг 15 Олон улсын зорчигч тээвэр




Олон улсад зорчигчдын тоо 1.1 сая болж өмнөх оны мөн үеэс 5.4%-аар өссөн. Үүнээс агаарын тээврээр олон улсад зорчигчдын тоо 855.9 мянган болж өмнөх оноос 17.8%-аар өссөн нь нийт олон улсад зорчигчдын 73.1%-ийг эзэлж байна. Төмөр замаар зорчигчийн тоо нийт олон улсад зорчигчийн 1.8%-ийг, автотээврээр зорчигчийн тоо 25.1%-ийг эзэлж байна.

Төмөр замаар олон улсад 21.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.6%-аар буурсан. Мөн автотээврээр олон улсад зорчигчдын тоо 2024 оны эхний хагас жилд онд 362.7 мянга байсан бол 293.8 мянга болж өмнөх оноос 19.0%-аар буурсан.

Бүх төрлийн тээврээр орон нутагт зорчигчдын тоо 2025 оны эхний хагас жилд 1.8 сая болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1%-аар буурсан байна.

Зураг 16 Орон нутгийн зорчигч тээвэр




2025 оны эхний хагас жилд автотээврээр 800.4 мянган зорчигч орон нутагт тээвэрлэсэн нь нийт орон нутгийн зорчигч тээврийн 43.3%-ийг, төмөр замын тээврээр 841.1 мянган зорчигч буюу 45.5%-ийг, агаарын тээврээр 207.3 мянган зорчигч буюу 11.2%-ийг эзэлж байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчсон зорчигчийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1%-аар, автотээврээр зорчсон зорчигчийн тоо 6.9%-аар өссөн бол төмөр замын орон нутгийн зорчигчдын тоо өмнөх оноос 12.1%-аар буурсан. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам баригдаж хөдөлгөөн нээсэн, мөн төмөр замын зорчигч тээврийн тариф 50

хүртэл хувиар нэмэгдсэн нь төмөр замын орон нутгийн зорчигчийн тоо жил бүр буурахад нөлөөлж байна.

2025 оны эхний хагас жилд нийт зорчигч эргэлт 3,976.7 сая хүн/км болж өмнөх оноос 10.8%-аар өсчээ. Үүнээс агаарын тээврийн зорчигч эргэлт хамгийн өндөр хувиар буюу 1723%-аар өсч, 2,489.4 сая хүн/км болжээ.

Зураг 17 Зорчигч эргэлт, сая хүн/км



БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР


**АВТОТЭЭВРЭЭР УЛС, ХОТ ХООРОНД
БОЛОН ХОТ ДОТОР НИЙТ 75.2 САЯ
ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.**

Зорчигч тээвэр

2025 оны эхний хагас жилд автотээврээр нийт 75.2 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.9%-аар, зорчигч эргэлт 1129.0 сая хүн/км болж 3.6%-аар тус тус өссөн байна. Үүнд нийслэлийн нийтийн тээврээр 74.1 сая зорчигч зорчиж өмнөх оноос 2.9%-аар өссөн нь нөлөөлжээ.


Хот хооронд буюу орон нутагт 800.4 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 6.9%-аар өссөн бол автотээврээр олон улсад 293 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 19.0%-аар буурсан байна.

Зураг 18 Автотээврийн зорчигч, сая хүн




Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2024 оны эхний хагас жил	2025 оны эхний хагас жил	Өсөлт бууралтын % 2025/2024 /хагас жил/
Нийт зорчигч тээвэр	хүн	73,110,559.0	75,213,600.0	2.9%
Олон улсад зорчигчид	хүн	362,682.0	293,790.0	-19.0%
Хот хоорондын зорчигч	хүн	749,112.0	800,439.0	6.9%
Хот доторх нийтийн тээврээр зорчигч	хүн	71,998,765.0	74,119,371.0	2.9%
Зорчигч эргэлт	сая.хүн/км	1,086.3	1,129.0	3.9%

Зураг 19 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр



Хөдөө орон нутгийн авто замын чанар сайжирч хатуу хучилттай авто зам нэмэгдсэнээр орон нутагт зорчих иргэдийн тоо нэмэгдсэн нь орон нутгийн зорчигчийн тоо өсөхөд голлон нөлөөлжээ.


Зураг 20 Автотээврийн зорчигч эргэлт



Нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо тогтмол өсч байгаа нь автотээврийн зорчигч эргэлт өсөхөд голлон нөлөөлжээ. Автотээврийн зорчигч эргэлт нийт зорчигч эргэлтийн 28.4%-ийг эзэлж байна.

АВТО ЗАМЫН ХИЛИЙН БООМТООР
АВТОТЭЭВРЭЭР 41.8 САЯ ТОНН АЧАА
ТЭЭВЭРЛЭЖ 37 ХУВИАР ӨСЛӨӨ.

Зураг 21 Автотээврийн ачаа тээвэр




Ачаа тээвэр

2025 оны эхний хагас жилд авто замын боомтуудаар нийт 39.5 сая тонн ачаа тээвэрлэсэн өмнөх оноос 4.8%-аар буурсан бөгөөд үүнээс 37.96 сая тонн экспортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 5.3%-аар буурч, 1.5 сая тонн импортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 10.6%-аар өсчээ.

Автотээврийн ачаа тээвэр	Хэмжих нэгж	2024 он хагас жил	2025 он хагас жил	Өсөлт бууралтын % 2025/2024 /хагас жил/
Нийт тээсэн ачаа	тонн	41,475,868.8	39,495,312.6	-4.8%
Ачаа оруулалт - импорт	тонн	1,387,541.7	1,534,096.0	10.6%
БНХАУ-аас	тонн	1,184,503.6	1,365,659.0	15.3%
ОХУ-аас	тонн	203,038.1	168,437.0	-17.0%
Ачаа гаргалт - экспорт	тонн	40,088,327.1	37,961,216.6	-5.3%
БНХАУ руу	тонн	40,068,244.6	37,916,967.6	-5.4%
ОХУ руу	тонн	20,082.5	44,249.0	120.3%
Ачаа эргэлт	сая.тонн/км	6,482.1	5,923.4	-8.6%

2025 онд тээсэн нийт экспортын ачааны 87.4%-ийг автотээврээр тээжээ.

Зураг 22 Автотээврийн экспортын ачаа




Автотээврийн экспортын ачааны 99.9%-ийг БНХАУ руу тээвэрлэсэн бол, 0.1%-ийг ОХУ руу тээвэрлэжээ.

Гашуунсухайт боомтоор хамгийн их 46.6% буюу 17.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 14.1%-аар буурсан үзүүлэлттэй байгаа бол Шивээхүрэн боомтоор 33.9% буюу 12.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 11.5%-аар өссөн байна. Ханги боомтоор 7.1% буюу 2.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 32.9%, Булган боомтоор 4.4% буюу 1.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 2.1%, Зам-Үүд боомтоор 0.8% буюу 310.8 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 29.1%, Баянхошуу боомтоор 0.6% буюу 214.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 1.6%-аар тус тус буурсан бол

Бичигт боомтоор 6.4% буюу 2.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 88.7%-аар өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 23 Экспортын ачаа, эзлэх хувь



Мөн ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 44.2 мянган тонн ачаа экспортод тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 98.7%-аар өсчээ.

2025 оны эхний хагас жилд автотээврээр 36.6 сая тонн нүүрс (-5.9%), 214.9 мянган тонн газрын тос (-1.6%), 112.8 мянган тонн төмрийн хүдэр (-68.6%) тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байгаа бол 738.6 мянган тонн зэсийн баяжмал (+54.1%), 173.3 мянган тонн жонш (+274.2%), 92.0 мянган тонн бусад ачаа (+46.0%) тээвэрлэсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2023 он хагас жил	2024 он хагас жил	2025 он хагас жил	Өсөлт бууралтын % 2025/2024 /хагас жил/
Нүүрс	тонн	27,203,435.7	38,919,910.7	36,629,772.1	-5.9%
Газрын тос	тонн	292,964.9	218,311.0	214,856.7	-1.6%
Зэсийн баяжмал	тонн	348,480.0	479,262.6	738,556.8	54.1%
Төмрийн хүдэр	тонн	136,638.7	358,817.5	112,752.5	-68.6%
Жонш	тонн	0.0	46,303.3	173,261.9	274.2%
Бусад	тонн	554,299.7	63,023.0	92,016.6	46.0%

Зураг 24 Автотээврийн импортын ачаа




Автотээврээр 2025 оны эхний хагас жилд нийт импортын ачааны 46.6%-ийг буюу нийт 1.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10.6%-аар өссөн үзүүлэлт байна. Импортын тээврийн 89.0%-ийг БНХАУ-тай, 11.0%-ийг ОХУ-тай хиллэдэг боомтуудаар тээвэрлэжээ.

Үүнээс Замын-Үүд боомтоор хамгийн их буюу 1,170.8 мянган тонн ачаа оруулж ирсэн нь өмнөх оны мөн үеэс +20.4%-аар, Гашуунсухайт боомтоор 139.7 мянган тонн оруулсан нь 8.0%-аар, Алтанбулаг боомтоор 131.2 мянган тонн оруулсан нь 30.2%, Ханги боомтоор 9.5 мянган тонн оруулсан нь 64.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Ачаа тээвэр боомтуудаар	2024 оны эхний хагас жил		2025 оны эхний хагас жил	
	Импорт	Экспорт	Импорт	Экспорт
Нийт ачаа, тонн	1,387,541.7	40,088,327.1	1,534,096.0	37,961,216.6
Боршоо	25,534.1	0.0	16,324.0	0.0
Цагаан нуур	76,738.0	0.0	20,894.0	0.0
Сүмбэр	0	0.0	0.0	0.0
Хавирга	18,163.5	27,950.7	13,168.0	55,552.0
Алтанбулаг	100,766.0	20,082.5	131,219.0	44,249.0
Баянхошуу	3,751.7	218,311.6	780.0	214,855.0
Бургастай	280.0	278,519.3	0.0	29,742.0
Замын-Үүд	972,328.5	438,159.0	1,170,766.0	310,757.0
Бичигт	3,685.0	1,283,140.0	0.0	2,421,423.0
Булган	0.0	1,690,072.0	0.0	1,653,952.0
Ханги	5,775.0	3,990,537.4	9,505.0	2,678,930.0
Шивээ хүрэн	51,200.0	11,545,842.0	31,720.0	12,868,981.0
Гашуунсухайт	129,320.0	20,595,712.6	139,720.0	17,682,775.6
БНХАУ	1,184,503.6	40,068,244.6	1,365,659.0	37,916,967.6
ОХУ	203,038.1	20,082.5	168,437.0	44,249.0
Нийт	41,475,868.8		39,495,312.6	

Зураг 25 Боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, эзлэх хувь



Автозамын боомтуудаар 2025 оны эхний хагас жилд нийт 396,727 ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бол үүнээс 65,000 тээврийн хэрэгсэл хилээр орсон, 331,727 тээврийн хэрэгсэл хилээр гарсан байна.

БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо 368,246 болж өмнөх оноос 10.3%-аар буурсан бөгөөд нийт хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн 92.8%-ийг эзэлж байна.


ОХУ-тай хиллэдэг боомтуудаар 28,481 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оноос 6.8%-аар буурсан нь ОХУ-д болж буй зөрчилдөөнөөс шалтгаалан буурчээ.

Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2024 он	2025 он	Өсөлт бууралтын % 2025/2024 /хагас жил/
	440,961	396,727	-10.0%
Орсон тээврийн хэрэгсэл	60,940	65,000	6.7%
БНХАУ-аас	46,397	50,401	8.6%
Бичигт	-	-	-
Баянхошуу	192	32	-83.3%
Булган	-	-	-
Бургастай	9	-	-
Гашуунсухайт	3,233	3,493	8.0%
Шивээхүрэн	1,280	1,523	19.0%
Замын-Үүд	41,074	44,720	8.9%

	Ханги	231	256	10.8%
	Хавирга	378	377	-0.3%
OХУ-аас		14,543	14,599	0.4%
	Алтанбулаг	6,232	6,075	-2.5%
	Боршоо	1,114	514	-53.9%
	Цагааннуур	7,197	8,010	11.3%
Гарсан тээврийн хэрэгсэл		380,021	331,727	-12.7%
БНХАУ-руу		364,014	317,845	-12.7%
	Бичигт	17,260	23,180	34.3%
	Баянхошуу	6,936	6,510	-6.1%
	Булган	23,363	23,158	-0.9%
	Бургастай	8,757	491	-94.4%
	Гашуунсухайт	165,525	146,680	-11.4%
	Шивээхүрэн	90,848	92,634	2.0%
	Замын-Үүд	6,896	3,863	-44.0%
	Ханги	44,174	20,814	-52.9%
	Хавирга	255	515	102.0%
	Сүмбэр	-	-	-
OХУ-руу		16,007	13,882	-13.3%
	Алтанбулаг	5,316	4,778	-10.1%
	Боршоо	1,125	505	-55.1%
	Цагааннуур	9,566	8,599	-10.1%

МОНГОЛ УЛСАД 1 388 481 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БҮРТГЭЛТЭЙ БАЙНА.

Зураг 26 Тээврийн хэрэгслийн ангилал




Тээврийн хэрэгслийг хүрдний байрлалаар авч үзвэл баруун буюу буруу жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл 830,689 буюу 66.7%, зүүн буюу зөв жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл 414,407 33.3%-ийг эзэлж байна.

Эхний хагас жилд баруун хүрдтэй тээврийн хэрэгсэл өмнөх оны мөн үеэс 20.3%-аар, зүүн хүрдтэй тээврийн хэрэгсэл 8.9%-аар нэмэгджээ.

Монгол Улсад 2025 оны хагас жилийн байдлаар 1,388,481 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 118,203 тээврийн хэрэгслээр буюу 9.3%-аар өссөн байна. Бүх төрлийн тээврийн хэрэгслийн өсөлтийн хувь ойролцоо байгаа нь ангилал тус бүрийн эзлэх хувьд өөрчлөлт оруулаагүй байна.

Хамгийн өндөр дүнгээр өссөн нь суудлын автомашин 91.4 мянгаар буюу 10.8%-аар өссөн бол хамгийн өндөр хувиар өссөн нь механизм 17.7%-аар буюу 3.4 мянгаар өссөн үзүүлэлт байна. Ачааны машин 10.5 мянгаар буюу 5.1%-аар өсчээ.

Зураг 27 Жолооны хүрдний байрлал





Хөдөлгүүрийн төрөл

- Хосолсон	517,114
- Бензин	436,451
- Дизель	333,121
- Хийн	16,155
- Цахилгаан	1,874


33.5%-ийг бензин, 25.5%-ийг дизель, 1.2%-ийг хийн түлштэй, 0.1%-ийг цахилгаан тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн тоо 1,874 болж өмнөх оны мөн үеэс 572 буюу 43.9%-аар өссөн нь хамгийн өндөр хувиар өссөн үзүүлэлт байна.

Зураг 28 Хөдөлгүүрийн багтаамж


Нийт тээврийн хэрэгслийг хөдөлгүүрийн багтаамжаар нь ангилбал:

1500 см ³ хүртэл	357,992
1501-2500 см ³	582,165
2501-3500 см ³	169,715
3501-4500 см ³	50,782
4501 см ³	139,100



Тээврийн хэрэгслийг хөдөлгүүрийн төрлөөр ангилбал, 39.6%-ийг хосолсон,

Зураг 29 Автомашины насжилт



10 ба түүнээс дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 1,105,924 бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 79.6% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна.


0-3 жилийн насжилттай 83,059 тээврийн хэрэгсэл 6.0%, 4-6 жилийн насжилттай 71,300 тээврийн хэрэгсэл 5.1%,

Улаанбаатар хотод 796,808 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 57.4%-ийг, орон

7-9 жилийн насжилттай 128,199 тээврийн хэрэгсэл 9.2%-ийг тус тус эзэлж байна.

2025 оны хагас жилээр автотээврийн хэрэгслийн улсын үзлэгт нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 74.7% буюу 1.0 сая тээврийн хэрэгсэл хамрагдсан нь өмнөх оны хамрагдалтын хувиас 2.5%-аар илүү байна.

нутагт 591,673 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 42.6%-ийг эзэлж байна.




		2023 он /хагас жил/	2025 он /хагас жил/	2025/2024
		Улсын хэмжээнд	Улсын хэмжээнд	Улаанбаатарт
Нийт тээврийн хэрэгсэл		1,270,278	1,388,481	796,808
				9.3%
Тээврийн хэрэгслийн төрлөөр	Суудал	843,750	935,190	583,963
	Ачаа	203,397	213,855	89,756
	Автобус	23,813	23,833	12,574
	Тусгай	11,439	12,871	8,635
	Цистерн	4,569	5,168	3,558
	Зүтгүүр	51,925	53,786	27,838
	Механизм	19,142	22,536	15,580
	Чиргүүл	77,938	81,887	41,434
Мотоцикл		34,305	39,355	13,470
				14.7%
Жолооны хүрдний байрлал		1,139,569	1,245,096	726,610
				9.3%
	Баруун	742,772	830,689	511,873
	Зүүн	396,797	414,407	214,737
				4.4%
Хөдөлгүүрийн төрөл		1,190,120	1,304,715	754,216
				9.6%
	Бензин	430,541	436,451	233,287
	Дизель	318,635	333,121	158,426
	Цахилгаан	1,302	1,874	1,596
	Газ	15,529	16,155	8,081
	Хосолсон	424,113	517,114	352,826
				21.9%
Насжилт		1,270,279	1,388,482	796,809
				9.6%
	0-3	82,826	83,059	56,494
	4-6	56,698	71,300	39,184
	7-9	123,372	128,199	93,742
	10 ба түүнээс дээш	1,007,383	1,105,924	607,389
				9.8%
Хөдөлгүүрийн багтаамж		1,187,687	1,299,754	750,599
				9.4%
	1500 см³ хүртэл	360,627	357,992	172,885
	1501-2500 см³	496,443	582,165	360,705
	2501-3500 см³	152,227	169,715	99,978
	3501-4500 см³	47,221	50,782	31,642
	4501 см³ дээш	131,169	139,100	85,389
				6.0%

Орон нутагт бүртгэлтэй тээврийн хэрэгслийг эзэлж буй хувиар задлан авч үзвэл, Өмнөговь аймагт 71,947 буюу 5.2%, Хөвсгөл аймагт 39,152 буюу 2.8%, Орхон аймагт 37,051 буюу 2.7%, Сэлэнгэ аймагт 34,926 буюу 2.5%, Дархан-Уул аймагт 34,233 буюу 2.5%, Өвөрхангай аймагт 32,523 буюу 2.3%, Баян-Өлгий аймагт 32,108 буюу 2.3%, Дорноговь аймагт 31,556 2.2%, Ховд аймагт 30,727 буюу 2.2%, Дорнод аймагт 26,877

буюу 1.9%, Төв аймагт 26,364 буюу 1.9%, Увс аймагт 24,931 буюу 1.8%, Баянхонгор аймагт 24,310 буюу 1.8%, Архангай аймагт 23,827 буюу 1.7%, Хэнтий аймагт 22,835 буюу 1.6%, Завхан аймагт 21,193 буюу 1.5%, Сүхбаатар аймагт 20,682 буюу 1.5%, Булган аймагт 17,911 буюу 1.3%, Говь-Алтай аймаг 17,369 буюу 1.3%, Дундговь аймаг 16,163 буюу 1.2%, Говьсүмбэр 4,982 буюу 0.4%-ийг эзэлж байна.


Зураг 30 Орон нутаг дахь тээврийн хэрэгслийн төрөл



БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ТӨМӨР ЗАМААР ОЛОН УЛСАД ЗОРЧИГЧДЫН ТОО 2.4 ДАХИН ӨСЛӨӨ.

Зураг 31 Төмөр замын зорчигч




Зорчигч тээвэр

Төмөр замаар 2025 оны эхний хагас жилд нийт 862.8 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 11.2%-аар буурсан байна.

